

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН  
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2020 ОНЫ 1 ДҮГЭЭР  
УЛИРЛЫН МЭДЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2020.03.31

Арвайхээр

Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2008 оны 44 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэдээс аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс албадад гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам”-ын дагуу иргэдээс гаргасан өргөдөл, гомдол саналыг цахим хуудас, нээлттэй утас болон амаар, үйлчилгээний нэгдсэн төвөөр хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн төрөөс иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй хүргэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар ажлын өдрүүдэд иргэдийг хүлээн авч биечлэн уулзаж, өргөдөл, гомдлыг амаар болон бичгээр хүлээн авч тэдний гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай 2020 онд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-нд иргэд, аж ахуйн нэгж болон харилцагч бусад байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах талаар арга хэмжээ тусган ажиллаж байна.

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллагад 2020 оны 1 дүгээр улиралд иргэдээс нийт 4550 өргөдөл, гомдол, санал ирүүлсэн байна. Үүнээс өргөдөл 4233 буюу 93.0 хувь, гомдол 275 буюу 6.0 хувь, санал 42 буюу 0.9 хувийг тус тус эзэлж байна.

Өргөдөл, гомдлын мэдээг урд оны мөн үетэй харьцуулахад нийт өргөдөл, гомдол, саналын тоо 1049-өөр өссөн боловч гомдлын тоо 47-оор буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны I улиралтай харьцуулсан байдал



Аймгийн хэмжээнд нийт 4550 өргөдөл, гомдол, санал ирсэний 4198 буюу 92.2 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдэж, 631 буюу 13.8 хувь нь бусад байгууллагад шилжүүлж, 352 буюу 7.7 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна.

Нийт ирүүлсэн өргөдлийг хэлбэрээр нь авч үзвэл бичгээр 4184 буюу 92.0 хувь, утсаар 332 буюу 7.3 хувь, биечлэн ирүүлсэн 18 буюу 0.4 хувь, цахимаар 16 буюу 0.3 хувийг тус тус эзэлж байна.


Нийт ирүүлсэн өргөдөл, гомдол, саналыг агуулгаар нь авч үзвэл нийгмийн халамжийн үйлчилгээтэй холбоотой 1124 буюу 24.7 хувь, иргэний бүртгэл, мэдээлэл 562 буюу 12.3 хувь, ажилд орох чөлөөлүүлэх 361 буюу 7.9 хувь, тэтгэвэр тогтоолгох 310 буюу 6.8 хувь, газар эзэмших, өмчлөх, шилжүүлэхтэй холбоотой 306 буюу 6.7 хувь, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудал 136 буюу 2.9 хувийг тус тус эзэлж байна.

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар аймгийн Засаг даргад хандаж мөнгөн тусламж хүсч өргөдөл ирүүлсэн 24 иргэнд 9.6 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгоод байна.

Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг Аймгийн “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 70321111 дугаарын утсаар хүлээн авч нийт 231 өргөдөл, гомдол, санал ирснээс 100 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна. Нийт ирсэн өргөдөл, гомдол, саналаас давхардсан тоогоор гомдол 192, мэдээлэл, тодруулга, санал 14-ийг тус тус ирүүлсэн байна.

“Үйлчилгээний нэгдсэн төв”-д ирсэн өргөдөл, гомдолыг урд оны мөн үетэй харьцуулахад гомдлын тоо 11.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны I улиралтай харьцуулсан байдал



Долоо хоног бүрийн Мягмар гаригт хуралддаг аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлаг, албадын дарга нарын “Шуурхай хуралдаан”-ыг 11 удаа зохион байгуулж, 7032-1111 утсанд иргэдийн ирүүлсэн санал, гомдлыг шийдвэрлэсэн талаарх мэдээллийг сонсч, зар 4, тодруулга 26, мэдээлэл 31, 38 удаагийн үүрэг даалгаврыг байгууллагын удирдлагуудад өгч ажиллалаа.

Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар нэгтгэн гаргаж, хавсралтаар хүргүүлж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН  
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2020.03.31

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт /Хувь/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Хугацаа болоогүй	
1.	Аймгийн ЗДТГазар	87	72	18	-	15	82.7
2.	Агентлагууд	537	437	1	-	100	81.3
3.	Сумд	3695	3458	381	1	237	93.5
4.	Аймгийн Үйлчилгээний нэгдсэн төв /70321111/	231	231	231	-	-	100
Дүн		<b>4550</b>	<b>4198</b>	<b>631</b>	<b>1</b>	<b>352</b>	<b>92.2</b>

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Н.ЭНХЦЭЦЭГ

НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН П.МӨНХЗУЛ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН  
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ /ХЭЛБЭРЭЭР/

2020.03.31

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Үүнээс:				
			Бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Бусад
1.	Аймгийн ЗДТГазар	87	87	-	-	-	-
2.	Агентлагууд	537	487	16	28	6	-
3.	Сумд	3695	3604	-	79	12	-
4.	Аймгийн Үйлчилгээний нэгдсэн төв /70321111/	231	6	-	225	-	-
<b>Дүн</b>		<b>4550</b>	<b>4184</b>	<b>16</b>	<b>332</b>	<b>18</b>	<b>-</b>
Хувь		100%	92.0%	0.3%	7.3%	0.4	-

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Н.ЭНХЦЭЦЭГ

НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН П.МӨНХЗУЛ

## ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН АГУУЛГА /ХУВИАР/

2020.03.31

## Арвайхээр

Аймгийн нэр	/тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/			
Өвөрхангай аймаг	Нийт өргөдөл, гомдол, санал 4550 ирсэн байна.	хүсэлт	4233	93.0%
		гомдол	275	6.04%
		санал	42	0.9%
	Нийгмийн халамжийн үйлчилгээ		1124	24.7%
	Иргэний бүртгэл, мэдээлэл		562	12.3%
	Ажилд орох, чөлөөлүүлэх		361	7.9%
	Тэтгэвэр тогтоолгох		310	6.8%
	Газар эзэмших, өмчлөх, шилжүүлэхтэй холбоотой		306	6.7%
	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой		136	2.9%
	<ul style="list-style-type: none"> <li>Долоо хоног бүрийн Мягмар гаригт хуралддаг аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлаг, албадын дарга нарын “Шуурхай хуралдаан”-ыг 11 удаа зохион байгуулж, 7032-1111 утсанд иргэдийн ирүүлсэн санал, гомдлыг шийдвэрлэсэн талаарх мэдээллийг сонсч, зар 4, тодруулга 26, мэдээлэл 31, 38 удаагийн үүрэг даалгаварыг байгууллагын удирдлагуудад өгч ажиллалаа.</li> <li>Арвайхээр суманд Мэргэд лаборатори сургуулийн 320 хүүхдийн сургууль, 150 хүүхдийн цэцэрлэг, Хужирт суманд 75 хүүхдийн цэцэрлэг, Хархорин суманд 320 хүүхдийн сургуулийн барилга, Нарийнтээл суманд 240 хүүхдийн сургуулийн барилгууд 2020 оны эхээр тус тус шинээр ашиглалтад орсон тул ажилд орох иргэдийн хүсэлт өссөн байна.</li> </ul>			

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА  
Н.ЭНХЦЭЦЭГ

НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН П.МӨНХЗУЛ